

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2018 оны эхний хагас жил)

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p style="text-align: center;"><i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p>	<p style="text-align: center;"><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p>	<p style="text-align: center;"><i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
Хоёр. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа		
<p>2.1. Нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу боловсруулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулах, Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) болон өдөр тутмын сонинд нийтлэх ажлыг хугацаанд нь хийнэ.</p>	<p>НИТХ-ын 2017 оны “Нийслэлийн 2018 оны төсөв батлах тухай” 02/22 дугаар тогтоол, 20 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн төсвийн 301,701.4 сая төгрөгийн 97 багц төсөл, арга хэмжээ, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 11,471.3 сая төгрөгийн 134 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргаас баталсан “Худалдан авах ажиллагааны 2018 оны ерөнхий төлөвлөгөө”-г төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)–д, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь заалтын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу “Монголын үнэн” сонины 2018 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дугаарт нийтлүүлж олон нийтэд мэдээлсэн.</p>	

<p>2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтын дагуу үнэлгээний хороонд иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж, урамшуулал олгоно.</p>	<p>Тус газраас 2016 оны НИТХ-ын 48 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 16 иргэн, НИТХ-ын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 79 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 77 иргэнийг тус тус батлуулан үнэлгээний хороонд олон нийтийн төлөөллөөр ажиллах боломжоор хангасан бөгөөд эдгээр иргэдийн төлөөлөлтэй зөвшилцсөнөөр үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилсон 48 удаагийн тушаалыг батлан үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан 14 иргэний төлөөлөлд 1,755,440 төгрөгийн урамшуулал олгосон.</p>	
<p>2.3. Төсөвт байгууллагын өөрийн орлогыг батлагдсан төсөв сар, улирлын хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлнэ.</p>	<p>2018 онд нийслэлийн төсвөөс тус байгуулагад 496,421.6 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, 20,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн. Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгээгүй ажилласан ба 63,072.6 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан байна.</p>	
<p>2.4. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын тогтоох тухай" журмыг хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим хуудаст тавигдах мэдээллийг сар бүр агуулга, нийтлэг стандартын дагуу нийтэлж олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Тус байгууллагын Хуулийн хэлтсээс шилэн дансны санхүүгийн мэдээллийг хянаж, 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зөвлөмж гаргасан бөгөөд холбогдох албан хаагчидтай хамтран хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон гишүүдээс нийт 153 ширхэг "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулан авч, уг мэдэгдлийг "shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.</p> <p>Байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлт хөдөлгөөний талаарх 1-6 сарын мэдээллийг цаг хугацааны хоцрогдолгүй сар бүр системд нийтэлсэн.</p> <p>Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл,</p>	

	<p>дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5,000.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг www.shilendans.gov.mn мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийн хамт байршуулан мэдээлж байна.</p>	
<p>2.5. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол маргааныг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх, гомдлын бүртгэл үүсгэн, судалгаа, дүгнэлт хийх, түүн дээр үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.</p>	<p>Тайлант хугацаанд тус газарт эрх шилжүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 50,954.6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, 33,834.9 сая төгрөгийн санхүүжих төсөвт өртөг бүхий 110 ажлын худалдан авах ажиллагааг зарлаж эхлүүлсэн ба эдгээр ажилтай холбоотой ШӨХТГ-т 3, Сангийн яаманд 20 гомдол тус тус гарсан.</p> <p>Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гарсан гомдлын шийдвэрлэлтийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 2, • тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах 1 шийдвэр ирүүлсэн. <p>Сангийн яаманд гарсан гомдлын шийдвэрлэлтийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 5, • тендерийг дахин зарлах 8, • тендерийг дахин үнэлэх 3, • шийдвэрлэгдээгүй байгаа 4 ажил байна. 	
<p>2.6. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль" болон холбогдох журам, жишиг бичиг баримтыг боловсронгуй болгох</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт заасныг үндэслэн "Тендерт оролцогчдод давуу эрх</p>	

<p>талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар уламжлан Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн Захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>олгох аргачлал”-ыг шинэчлэх төсөлд тусгах санал боловсруулан 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 02/236 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.</p>	
<p>2.7. Төрийн дээд шатны болон Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, зааврын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, шалган зааварласан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх 16 ажлыг төлөвлөн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.</p> <p>Нийслэл дэх Төрийн аудитын газраас худалдан авах ажиллагааны чиглэлээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/59 дугаар тушаалаар баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
<p>2.8. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчлийг судлах, түүнийг залруулах, худалдан авах ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>НЗДТГ-ын ТЗУХ-т Байгууллагын үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж, 2016, 2017, 2018 оны ажлуудын судалгааг боловсруулж дүгнэлт хийж ажилласан. Худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж 2018 оны 01/54, 01/246 дугаа албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүргүүлэв.</p> <p>Газрын даргын 2018 оны 03 дугаар сарын А/32 тоот тушаалаар байгуулагдсан тус газраас зарласан тендер шалгаруулалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүд болон албан бичгүүдийн жишиг загварыг боловсруулах ажлын хэсэг байгуулан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам”, “Худалдан авах</p>	

	ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд"-ийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батлан газрын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.	
2.9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчид давуу эрх тооцох аргачлал"-ын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцно.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт заасныг үндэслэн "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ыг шинэчлэх төсөлд тусгах санал боловсруулан 2018 оны 02/236 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажилласан.</p> <p>Тус газарт эрх шилжин зохион байгуулагдаж буй 109 ажлын тендерийн баримт бичигт давуу эрх тооцохоор тусгаж зарласан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчдод давуу эрх тооцох аргачлал"-ын дагуу дотоодын давуу эрх тооцохоор хүсэлт болон нотлох баримтаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд дотоодын давуу эрхийн зөрүүг журмын дагуу тооцон ажиллаж байна.</p> <p>Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар "Тендерт оролцогчдод давуу эрх тооцох аргачлал" шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/610 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 33 байгууллагад тус аргачлалыг мөрдөн ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.</p>	
2.10. Бараа худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцлах ба Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу дотоодын үйлдвэрээс	Тус газарт нийт 12,474.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 65 удаагийн бараа худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт нь Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барааны жагсаалтад багтсан тул импортоор ирж байгаа бараанаас тусад нь 12 багцад багтаан худалдан авахаар тендер	

<p>худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусгана.</p>	<p>шалгаруулалтыг зохион байгуулсан. Үүний дүнд 10 багц ажилд 2,649,501.6 мянган төгрөгийн өртөг бүхий 64 нэр төрөл бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.</p>	
<p>2.11. Худалдан авах ажиллагааны чанар, үр дүнгийн талаар тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн сэтгэл хангамжийг тодорхойлох судалгаа зохион байгуулах, үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>“Хариуцлагын жил”-ийн хүрээнд хэрэглэгчийн үнэлгээний судалгааг 12 дугаар сард зохион байгуулж, үр дүнг нэгтгэн, түүний дагуу цаашид авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>	
<p>2.12 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж, Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Бодлогын баримт бичгүүдэд худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн цахим системийг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэх, тендерийн цахим хэлбэрээр зохион байгуулж бүрэн ил тод, нээлттэй болгох зорилт тусгагдсаны дагуу Нийслэлийн Засаг даргаас тус газарт улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 88,423.4 сая төгрөгийн 151 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа эрх шилжин ирсэн. Үүнээс тендер зарлагдсан улс, нийслэлийн төсвөөр хэрэгжих 60 ажил, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 1/78 дугаар албан бичгээр эрх шилжин ирсэн 50 /багц/ ажлын нийт 110 төсөл, арга хэмжээг Төрийн цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, биелэлтийг 100 хувь ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд нийт зарлагдсан төсөл, арга хэмжээний 54.2 хувь буюу 191,674.1 сая төгрөгийн 440 төсөл, арга хэмжээг цахим системээр зохион байгуулсан байна. Үүнтэй холбоотой биелэлтийг хангуулах чиглэлээр 2018 оны 02/57 болон 01/297 дугаар албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн ба биелэлтийг зохих журмын дагуу үнэлж, 01/269, 01/708 дугаар албан бичгээр</p>	

	НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж ажилласан.	
2.13. Тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Тус газарт эхний хагас жилийн байдлаар 59 тогтоол, шийдвэрийн нийт 192 заалт 85 хувийн хэрэгжилтэй байна. Үүнд, Ерөнхийлөгчийн зарлиг 1, хэрэгжилт 100 хувь, Ерөнхий сайдын захирамж 1, хэрэгжилт 88 хувь, Засгийн газрын тогтоол 4, хэрэгжилт 89 хувь, Засгийн газрын албан даалгавар 1, хэрэгжилт 82 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 6, хэрэгжилт 93 хувь, НИТХ-ын тогтоол, шийдвэр 1, хэрэгжилт 75 хувь, худалдан авах ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын захирамж 22, хэрэгжилт 41 хувь, захиргааны үйл ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын захирамж 7, хэрэгжилт 94 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 5, хэрэгжилт 91 хувь, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар 11, хэрэгжилт 100 хувьтай байна. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг зохих журмын дагуу үнэлж 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 01/812 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлж, http://lmonitoring.ub.gov.mn программд заасан хугацаанд тайлагнасан.	
2.14. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж мэдээ, тайланг Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тухай удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. НЗДТГ-аас 2018 оны 06 дугаар сард зохион байгуулсан "Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ, чадавхийг бэхжүүлэх нь" сургалтад 1 албан хаагч хамрагдаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж байна.	
2.15. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын	2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар "Төсвийн сахилга бат хариуцлагыг сайжруулах" төлөвлөгөө	

<p>нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн тайлагналын заавар, журмыг хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>баталсан. Сангийн сайдын 2017 оны 348 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал”-ыг байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тооцооны хуудас, орлогын жагсаалтуудын маягтыг 2018 оны А/35 дугаар тушаалаар баталж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.</p>	
<p>2.16. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт болон хангамжийн материалын зарцуулалтыг сайжруулах, тооллого бүртгэлийг тогтсон хугацаанд явуулах.</p>	<p>Байгууллагын үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг үндэслэн Эд хөрөнгийн тооллогын комисс болон Өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, санхүүгийн тайланд бүртгэлтэй машин, тоног төхөөрөмжүүдээс элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн. Байгууллагын үндсэн хөрөнгийг коджуулж, өмчийн шинэ програмд бүртгэсэн. Мөн 2018 оны 01 дүгээр улиралд НӨХГ-ын хөрөнгийн бүртгэлтэй байгууллагын хөрөнгийг тулган баталгаажуулсан. 2017 онд НӨХГ-тай хийсэн нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дүгнэж, нийт 85 оноо авахаас 84 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авч ажилласан.</p>	
<p>2.17. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>Стандартчилалын үндэсний төвийн 2011 оны 54 дүгээр тогтоороор батлагдсан “Төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах стандарт”-д нийцүүлж байгууллагын цахим хуудсын бүтэц, агуулгад өөрчлөлт хийсэн ба Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлж ажилласан.</p>	
<p>2.18. Тус байгууллагаас 2017 онд баталсан "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>"Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг газрын даргын 2018 оны А/13 дугаар тушаалаар батлан, байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст нээлттэй байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
<p>2.19. Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтуудын</p>	<p>Газрын даргын 2018 оны А/82 дугаар тушаалаар албан хаагчдын 2018 оны сургалт сургалтын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг</p>	

<p>эрэлт хэрэгцээг тодорхойлон төлөвлөгөө баталж, холбогдох төрийн болон сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах.</p>	<p>ханган ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад 2 удаагийн сургалтыг явуулаад байна.</p>	
<p>2.20. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хууль тогтоомж болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>Газрын 2018 оны Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 03 дугаар сарын 19-ний өдрийн А/30 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч буй мэдүүлэг гаргагч 8 албан тушаалтны 2017 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргасан ба ХАСХОМ-1 тайланг хугацаанд нь хүргүүлсэн.</p> <p>Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 153 төлөөллийн ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг хянаж “shilendans.gov.mn” системд мөн тус газраас үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан 46 төлөөллийн мэдэгдлийг АТГ-ын цахим системд байршуулж, мэдүүлсэн.</p> <p>Хэлтсийн даргаар томилогдсон 3, ахлах мэргэжилтнээр томилогдсон 5 албан хаагч болон үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан 46 төлөөлөлд тухай бүр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн талаар ерөнхий мэдээлэл хийж, хориглох зүйлсийг тусгайлан танилцуулж ажилласан.</p> <p>Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон албан хаагчдад хориглох зүйлсийн талаар 7 заалт тусган, ажлын байрны өрөө тасалгаа бүрт авлигын хор уршгийн эсрэг 4 төрлийн зурагт</p>	

	хуудсыг байршуулж авилгаас татгалзах, авилгыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж байна.	
2.21. Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлж, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомж, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 05 сарын 14-ний өдөр баталж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Мөн ёс зүйн зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор Ёс зүйн дүрэм болон ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулан шинэчилсэн.	
2.22. Архивын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн заавар, Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу удирдлагын баримт болон тендерийн материалыг 1 дүгээр улиралд багтаан архивлана.	<p>Газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг томилж, Архивын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн зааврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын баримт бичиг болон удирдлагын үйл ажиллагааны баримтыг дараа оны эхний улиралд багтаан архивлахаар тусгасан. 2018 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын 1 дүгээр хурлаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 2017 онд худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж гэрээ байгуулагдсан 296 ажлын баримтаар цаасан суурьт архивын нэгж үүсгэснээс байнга хадгалах 252, түр хадгалах 44 хадгаламжийн нэгжийг тус тус үүсгэсэн. Мөн 2017 онд цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендерт оролцогч аж ахуйн нэгжийн тендерийн материалыг 276 хадгаламжийн нэгж /CD/-д хуулбарлан хадгалалтын болон хамгаалалтын хувь үүсгээд байна.</p> <p>Захиргааны үйл ажиллагаатай холбоотой байнга хадгалах 48, түр хадгалах 103, 70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгжийг үүсгэсэн.</p>	

	Архивын хадгаламжийн сангаас байнга хадгалах 7 хадгаламжийн нэгж, 136 хуудас баримтыг зохих журмын дагуу бусад байгууллагад ашиглуулсан.	
2.23. Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол санал хүсэлтийг www.smartcity.mn/ub.1200.mn/ цахим системээр хүлээн авч, ажлын 5 хоногт багтаан үндэслэлтэй шийдвэрлэнэ.	Өргөдөл гомдол, хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэхээр зорилт тавьсан ба тайлант хугацаанд 33 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цахим системд бүртгэн дунджаар ажлын 5 хоног 17 цаг 43 минутад хуулийн дагуу бүрэн шийдвэрлэсэн.	
2.24. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн “eDOC” системийг стандартын дагуу хөтөлнө.	<p>Тайлант хугацаанд нийт ирсэн бичгийн тоо 680 байгаагаас хариутай 170, хариугүй 510 байна. Нийт шийдвэрлэгдсэн бичгийн тоо 652, шийдвэрлэх шатандаа байгаа бичгийн тоо 9, хугацаа хэтрэн шийдвэрлэсэн бичгийн тоо 19 байна. Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.7%, үүнээс ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.5% байна. Тус газраас тайлант хугацаанд нийт 812 албан бичиг явуулсан байна.</p> <p>Мөн стандартын зөрчилтэй 11, систем ашиглалтын зөрчилтэй 3, шийдвэрлэх хугацааны зөрчилтэй 57, шийдвэрлэлтийн зөрчил 2, нийт зөрчилтэй 73 албан бичиг байна.</p> <p>Албан хэрэг хөтлөлтийн зөрчлийг бууруулах зорилгоор нийт албан хаагчдын хурлаар зөрчлийн ангилалыг дэлгэрэнгүй мэдээлж, цаашид албан бичиг хүргүүлж буй байгууллагын нэрийг зөв бичих, стандартын зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгч, үндсэн стандарт, бусад холбогдох журам зааврыг мөрдлөгө болгон ажиллаж байна.</p>	
Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО		

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</p>	<p>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</p>	<p>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</p>
<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>
<p>1.1. Нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль, журам болон Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолд нийцүүлэн зохион байгуулах, хэрэгжүүлэх асуудлаар 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албад, Нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад заавар, зөвлөмж хүргүүлнэ.</p>	<p>Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай 2018 оны 01 дүгээр сарын 02/57 дугаар, 2018 оны 04 дүгээр сарын 01/297 дугаар, 05 дугаар сарын 02/610 дугаар албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Сангийн яамнаас Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг 2018 оны 01/299 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Үүний дүнд НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжид нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуурт "худалдан авах ажиллагааг тайлагнасан, цахим системд ил тод байдлыг хангасан эсэх" үзүүлэлтийг тусгасан.</p> <p>НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 сарын 18-ны өдрийн А/333 дугаар захирамжийг батлуулж, нийслэлийн төсвийн хүрээний байгууллагууд худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг тус газарт нэгтгэх, уг тайланд Нийслэлийн Дотоод аудитын алба хяналт тавихаар үүрэгжүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргаас нийслэлийн харьяа 12 байгуулагад эрх шилжин зохион байгуулагдаж буй нийт 100 төсөл, арга хэмжээний</p>	

	<p>худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тус газраас томилогдон ажиллахдаа худалдан авах ажиллагаа, хууль, журамд нийцүүлэн зохион байгуулах, анхаарах асуудлын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар “Тендерт оролцогчдод давуу эрх тооцох аргачлал” шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/610 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 33 байгууллагад тус аргачлалыг мөрдөн ажиллах талаар санал хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагын санхүү бүртгэлийн ажилтнуудад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 2018 оны 06 дугаар сард НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран зохион байгуулсан.</p>	
<p>1.2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн ашиглалт болон худалдан авах ажиллагааны хууль, журмын талаар сургалтыг 2 удаа зохион байгуулж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албад, Нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 100-120 албан хаагчийг хамруулна.</p>	<p>Худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр зохион байгуулахтай холбоотой 2018 оны 01 дүгээр сарын 02/57 болон 01/297 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд ТӨБЗГ-тай хамтран Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны алба, Нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 101 албан хаагчидад Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт болон ХАА-ны хууль, журмын талаар сургалт зохион байгуулсан.</p>	
<p>1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, Засгийн</p>	<p>9-10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ажил</p>	

<p>газрын тогтоол болон Нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан эсэх талаар Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад хяналт тавьж, шалган зааварлах ажлыг 9-10 дугаар сард багтаан зохион байгуулна.</p>		
<p>1.4. Нийслэлд нэвтрүүлж буй дундын мэдээллийн open.ulaanbaatar.mn системийг бүрэн ашиглаж, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг хууль, журмын дагуу ил тод, шуурхай мэдээлнэ.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/268 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн системийн үйл ажиллагааны журам”-ын дагуу http://open.ulaanbaatar.mn/map/ цахим системд худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн захирамжийг НЗДТГ-ын БТХ-ээс системд бүртгэж шилжүүлсэн тухай бүрт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс тендер зохион байгуулалтын талаарх мэдээллийг ил, тод нээлттэй болгож олон нийтэд хүргэж байна. Тайлант хугацаанд тус газарт эрх шилжүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 50,954.6 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 110 ажлын мэдээллийг үнэлгээний хороотой холбож журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
<p>1.5. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тус газарт эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр уг цахим систем болон өөрийн байгууллагын www.ub-procurement.mn цахим хуудаст оруулж, тендерийн урилгыг</p>	<p>2018 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж ирсэн 88,423.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 151 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн тус газарт эрх шилжиж ирсэн нийт 151 ажлаас 110 ажлын худалдан авах ажиллагааг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, байгууллагын www.ub-procurement.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг тухай бүр нийтэлж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн</p>	

<p>өдөр тутмын сонинд нийтлэн олон нийтэд мэдээлнэ.</p>	<p>21.1 дэх заалтын дагуу тендерийн урилга, зарыг өдөр тутмын “Засгийн газрын мэдээ” сонинд 43, “Монголын мэдээ” сонинд 46, “Зууны мэдээ” сонинд 3 удаа тус тус нийтэлж, тендерт оролцохыг сонирхогч этгээдэд ил тод, нээлттэй зарлан мэдээлж байна.</p>	
<p>1.6. Тендерт оролцогч аж ахуйн нэгж, иргэний төлөөлөлд хууль, журмыг сурталчлах, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн ашиглалтыг дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулна.</p>	<p>9-10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ажил</p>	
<p>1.7. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2018 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу нэгтгэж, Нийслэлийн Дотоод аудитын албаар хянуулан, 2019 оны 01 сарын 15-ны өдрийн дотор Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайлан, мэдээг нэгтгэн, Нийслэлийн Дотоод аудитын албаар хянуулж, 2018 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01/44 дугаар албан бичгээр НИТХ-ын ажлын алба, НЗДТГ, ХШҮХ, СТСХ, БТХ-т, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/150 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/692 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг дарга, НЗДТГ, НИТХ-ын ажлын алба, ТӨБЗГ-т тус тус хүргүүлж, Нийслэлийн Дотоод аудитын албаар хянуулан НЗД-ын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/2481 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажиллаа.</p>	
<p style="text-align: center;">Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i>		<i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i>
1		2	3
1. Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:	а) Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 05 сарын 14-ний өдөр баталж, 2 удаагийн сургалт зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан. Ёс зүйн дүрэм болон ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг байгууллагын http://ub-procurement.mn/ цахим хуудаст байршуулан шинэчилсэн.	
Зорилт-1: Ёс зүйн зөрчилгүй хамт олон байна.	б) Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль дүрмийн талаарх шат дараалсан мэдээлэл, сургалт зохион байгуулна.	Газрын даргын 2018 оны А/82 дугаар тушаалаар албан хаагчдын 2018 оны сургалт сургалтын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад 2 удаагийн сургалтыг явуулаад байна.	
Зорилт-2: Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль дүрэм, эрх зүйн актуудын талаар бүрэн мэдлэг, мэдээлэлтэй хамт олон байна.	в) Ажлын цаг ашиглалтыг сайжруулан, хоцрогдлыг арилгана.	Ажлын цаг ашиглалтын журмын хэрэгжилтийг ханган сар бүр албан хаагчдын ирц, цаг ашиглалтын судалгааг удирдлагад танилцуулж, уг журмыг удаа дараа зөрчсөн 6 албан хаагчдад 2018 оны 02 дугаар сарын Б/24-Б/29 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, 7 албан хаагчид анхааруулах хуудас олгосон.	

		Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 12 хоног ажил тасалсан Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Б.Сэргэлэнд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцож ажилласан.	
	г) Иргэд, үйлчлүүлэгчээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.	Тайлант хугацаанд 33 өргөдөл, хүсэлтийг бүртгэн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 17 цаг 43 минут байна. Өргөдөл гомдолтой холбоотой асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой алдаа дутагдал гаргаагүй байна.	
	д) Албан хэрэг хөтлөлтийг журам, стандартын дагуу зохион байгуулж, зөрчил дутагдалгүй ажиллана.	Тус газарт албан хэрэг хөтлөлтийг журам, заавар, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа бөгөөд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системд гарсан зөрчилтэй холбоотойгоор цаашид давтан гаргахгүй, албан бичгийн шийдвэрлэлтийг хууль зүйн үндэслэлийг тодорхой тусгах, иргэн, хуулийн этгээдэд хариуг тухай бүр мэдэгдэж байхад онцгой анхаарч ажиллах талаар нийт албан хаагчдын хурлаар үүрэг болгон ажилласан. Мөн зөрчил үүсгэсэн албан хаагчдад сануулах хуудас өгч, зөрчил давтагдсан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулахыг мэдэгдсэн ба заавар зөвлөмжөөр хангаж ажилласан.	
2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Байгууллагын цахим хуудсыг төрийн	а) Байгууллагын цахим хуудсыг шинэчилж бүрэн ашиглалтад оруулсан байна.	Стандартчилалын үндэсний төвийн 2011 оны 54 дүгээр тогтоороор батлагдсан “Төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах стандарт”-д нийцүүлж байгууллагын цахим хуудсын бүтэц, агуулгад	

<p>байгууллагын цахим хуудаст тавих шаардлага, стандартад нийцүүлэн хөгжүүлж ажиллана.</p>		<p>өөрчлөлт хийсэн ба Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлж ажилласан.</p>	
	<p>б) Албан хаагч бүр өөрийн хариуцан хэрэгжүүлж буй ажил үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд мэдээлэн, сурталчилна.</p>	<p>2017 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах” журмын дагуу хэлтэс нэгж, албан хаагчид үйл ажиллагаатай холбоотой 25 төрлийн мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн.</p> <p>Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж тайлан хугацаанд 50,954.6 төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 110 төсөл, арга хэмжээ буюу зарлагдсан тендерийг 100 хувь цахим системээр зохион байгуулж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон байгууллагын цахим хуудас http://ub-procurement.mn/ -д тендерийн урилга, зар, тендерийн баримт бичиг түүнтэй холбоотой зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэргийг файл хэлбэрээр татан авч үзэх боломтой байдлаар нийтлэсэн. Мөн тендерийн нээлтийн мэдээлэл, сонгон шалгаруулалтын үр дүнг тухай бүр иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж ажилласан.</p>	
<p>3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: Худалдан авах ажиллагааны газрын 2019 оны төсвийн төлөвлөлт,</p>	<p>а) Аудит, дотоод аудит хийгдсэн байна. -Мэдээллийн ил тод байдлыг хангаж, “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын тус газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын гэрчилгээ, дүгнэлтийг 2018 оны 02 дугаар сард ирүүлсэн бөгөөд “зөрчилгүй” санал дүгнэлт авсан. Төсвийн үргүй зардлыг багасган, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хэмнэлтийн горимд</p>	

<p>2018 оны төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулна.</p>		<p>шилжин ажиллах зорилгоор 2018 онд 496.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 476.4 сая төгрөг төсвөөс санхүүжих, 20 сая төгрөг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн.</p> <p>Тайлант хугацаанд 247.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 184.3 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд 63.0 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан байна. Өөрийн үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөөнд жилийн 20.0 сая төгрөг байхаар төсөвлөгдсөн ба эхний хагас жилийн байдлаар 9.0 сая төгрөгийн орлого төлөвлөсөнөөс 10.7 сая төгрөгийн орлого орж 1.7 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна.</p>	
<p>Зорилт-2: Санхүүгийн тайлан, төсвийн мэдээлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг ил тод мэдээлнэ.</p>	<p>б) Нийслэлийн Аудитын газрын дүгнэлт болон санхүүгийн холбогдолтой мэдээллийг ил тод болгож, байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллана.</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын тус газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын гэрчилгээ, дүгнэлтийг 2018 оны 02 дугаар сард ирүүлсэн бөгөөд заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, шилэн дансны цахим хуудас болон байгууллагын цахим хуудаст байршуулсан.</p>	
<p>4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, эмх цэгцийг дээшлүүлж ажиллана.</p>	<p>а) Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж эд, хөрөнгө болон хангамжийн материалын тооллогыг төлөвлөгөөний дагуу явуулах зорилгоор байгууллагын хөрөнгийг өмчийн програм болон НӨХГ-ын хөрөнгийн програмд бүртгэн, коджуулсан. Мөн хүний нөөцийн өөрчлөлт хөдөлгөөнтэй холбоотой “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2018 оны А/50 дугаар тушаалаар шинэчлэн томилж,</p>	

		<p>хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.</p> <p>Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу НӨХГ-т хүсэлт гаргаж эвдрэлтэй, элэгдлийн хугацаа дууссан хөрөнгийг актлуулж шийдвэрлүүлсэн.</p>	
	<p>б) Эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг үнэн зөв хийнэ.</p>	<p>Байгууллагын үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг үндэслэн Эд хөрөнгийн тооллогын комисс болон Өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, санхүүгийн тайланд бүртгэлтэй машин, тоног төхөөрөмжүүдээс элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>Байгууллагын үндсэн хөрөнгийг коджуулж, өмчийн шинэ програмд бүртгэсэн. Мөн 2018 оны 01 дүгээр улиралд НӨХГ-ын хөрөнгийн бүртгэлтэй байгууллагын хөрөнгийг тулган баталгаажуулсан. 2017 онд НӨХГ-тай хийсэн нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дүгнэж, нийт 85 оноо авахаас 84 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авч ажилласан.</p>	
<p>5.Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх талаар:</p> <p>Зорилт-1: Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан батлаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>а) Мэргэшүүлэх болон хувь хүний хөгжлийг дэмжих, хууль журмын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>Газрын даргын 2018 оны А/82 дугаар тушаалаар албан хаагчдын 2018 оны сургалт сургалтын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад 2 удаагийн сургалтыг явуулаад байна. Хууль журмын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 9 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт 18 албан хаагчийг хамруулсан.</p>	
	<p>б) Шинээр томилогдсон</p>	<p>Шинээр томилогдсон албан хаагчдад хөдөлмөрийн</p>	

	албан хаагчийг дадлагажуулах ажлыг зохион байгуулна.	дотоод журам болон бусад дүрэм, журмуудыг танилцуулахын зэрэгцээ мэргэшсэн албан хаагчдыг дагалдуулан ажиллуулж дадлагажуулах ажлыг тухай бүр хийж ажиллаж байна.	
	в) Нийгмийн баталгааг хангах чиглэлээр хуулийн хүрээнд боломж нөхцөлийг судалж, хэрэгжүүлнэ.	Тус байгууллагын 2018 оны төсөвт нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 5 сая төгрөгийн төсөв хуваарилагдсан. Нийгмийн баталгааг хангах чиглэлээр хуулийн хүрээнд боломж нөхцлийг судалж, Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулсан.	
Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО			

ДӨРӨВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-1: Хууль, журмын талаарх мэдлэгээ дээшлүүлж, мэргэжил дээшлүүлж суралцана. <i>(шалгуур үзүүлэлт)</i> А) Монгол Улсын Их сургуульд эдийн засгийн чиглэлээр суралцаж, магистрын зэрэг хамгаалах</p>	<p>Эдийн засгийн чиглэлээр 2018-2019 оны хичээлийн жилд суралцахаар бэлтгэж байна.</p>	
<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -2: Худалдан авах ажиллагааны чиглэлээр олон улсын туршлага судалж, практикт хэрэгжүүлнэ. <i>(шалгуур үзүүлэлт)</i> А) Худалдан авах ажиллагааны сайн туршлагыг судалж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.</p>	<p>2018 оны сүүлийн хагас жилд АНУ-ын Азийн сан, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахаар урьдчилан тохирч, бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын ДУНДАЖ ОНОО</p>		

ТАВ. НЭМЭЛТЭЭР ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p>Нэмэлтээр үүрэг болгосон арга хэмжээний үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</p>	<p>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</p>	<p>Тухайн арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</p>
<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>
<p>"Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" ЗГ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах;</p>	<p>Газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 01 ний өдрийн А/09 дугаар тушаалаар "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна. Мөн төлөвлөгөөний биелэлт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Хяналт шинжилгээ, үнэлгээний удирдамж, ажлыг хэсгийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/76 тушаалаар батлаад байна.</p>	
<p>МУ-ын Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоол, 2018 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;</p>	<p>Уг тогтоолуудаар батлагдсан 10 заалтаас тус газрын чиг үүрэгт хамааралтай 4 заалтын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, биелэлтийг 100 хувь хангасан ба 2018 оны 06 сарын 21-ний өдрийн 01/812 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-г хүргүүлж, http://lmonitoring.ub.gov.mn программд заасан хугацаанд тайлагнасан.</p>	

Арга хэмжээний үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)
1	2
<p>1.5. Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд тус газарт эхний хагас жилийн байдлаар 59 тогтоол, шийдвэрийн нийт 192 заалт 85 хувийн хэрэгжилтэй байна. Үүнд, Ерөнхийлөгчийн зарлиг 1, хэрэгжилт 100 хувь, Ерөнхий сайдын захирамж 1, хэрэгжилт 88 хувь, Засгийн газрын тогтоол 4, хэрэгжилт 89 хувь, Засгийн газрын албан даалгавар 1, хэрэгжилт 82 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 6, хэрэгжилт 93 хувь, НИТХ-ын тогтоол, шийдвэр 1, хэрэгжилт 75 хувь, худалдан авах ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын захирамж 22, хэрэгжилт 41 хувь, захиргааны үйл ажиллагаатай холбоотой Нийслэлийн Засаг даргын захирамж 7, хэрэгжилт 94 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 5, хэрэгжилт 91 хувь, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар 11, хэрэгжилт 100 хувьтай байна.</p>
<p>1.6. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд дагаж мөрдөнө.</p>	<p>Ёс зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 05 сарын 14-ний өдөр баталж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдад хориглох үйл ажиллагааны 19 зүйл, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон албан хаагчдад хориглох 7 зүйлийг тусган шинэчлэн боловсруулсан.</p>
<p>1.7. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөр, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг асуудал хариуцсан орлогчид тайлагнаж, үр дүнг Засаг даргын өмнө хариуцна.</p>	<p>“Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг улирал, эхний хагас жилийн байдлаар 01/269, 01/708 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж ажилласан.</p>
<p>1.8. Улаанбаатар хотын “Аз жаргалтай хот индекс”-ийн</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төрийн болон орон нутгийн</p>

<p>шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллана.</p>	<p>өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ” зорилтыгн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг</p> <ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааны дундаж хугацаа • Нийт худалдан авах ажиллагаанд гомдол үүссэн ажлын эзлэх хувь • Нийт худалдан авах ажиллагаанд үүссэн зөрчил ба түүний нийт ажилд эзлэх хувь <p>гэсэн 3 үзүүлэлтээр 2016, 2017, 2018 оны ажлуудын мэдээлэлд KPI үнэлгээг хийж, дүгнэлт гаргасан. KPI үнэлгээгээр тооцох, аргачлалыг 2018 оны 01/54, 01/246 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллахаар бүртгэл, дата хөтлөн ажиллаж байна.</p>
<p>1.9. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлүүлнэ.</p>	<p>Байгууллагын үндсэн чиг үүргийн чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор</p> <ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааны дундаж хугацаа • Нийт худалдан авах ажиллагаанд гомдол үүссэн ажлын эзлэх хувь • Нийт худалдан авах ажиллагаанд үүссэн зөрчил ба түүний нийт ажилд эзлэх хувь <p>гэсэн 3 үзүүлэлтээр худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг KPI үнэлгээгээр тооцох, аргачлалыг томъёолж, 2016, 2017, 2018 оны ажлуудын судалгааг боловсруулж дүгнэлт хийж ажилласан. KPI үнэлгээгээр тооцох, аргачлалыг 2018 оны 01/54, 01/246 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллахаар бүртгэл, дата хөтлөн ажиллаж байна.</p>
<p>1.10. 2018 оныг “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан энэхүү ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>"Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 2018 оны А/07 дугаар тушаалаар баталсан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/918 захирамжийн дагуу тус газрын удирдлагууд ЧД-ийн 8, 10, 11, 12 дугаар хороодод ажиллаж, тайланг илтгэх хуудсаар хүргүүлж байна.</p>

<p>1.11. Байгууллагын хэмжээнд тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай асуудлаар 2-оос доошгүй ажлыг санаачилж хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангах зорилгоор 3 төрлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд захирамжийн төслөөр санал хүргүүлсэн. Үүнтэй холбоотой:</p> <p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загварт тухайн жилийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хэрэгжүүлэх асуудлыг нэмж тусгуулах саналыг 2018 оны 01/219 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн. Үүний дүнд НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжид "худалдан авах ажиллагааг тайлагнасан, цахим системд ил тод байдлыг хангасан эсэх" үзүүлэлтийг тусгасан.</p> <p>НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэстэй хамтран Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 сарын 18-ны өдрийн А/333 дугаар захирамжийг батлуулж, нийслэлийн төсвийн хүрээний байгууллагууд худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг тус газарт нэгтгэх, уг тайланд Нийслэлийн Дотоод аудитын алба хяналт тавихаар үүрэгжүүлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, 46 дугаар зүйл 46.1 дэх заалтын дагуу тендерт оролцогчдын шалгарсан болон шалгараагүй тухай мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлэх тухай захирамжийн төсөл нь шийдвэрлэгдээгүй байна.</p>
<p>1.12. 2017 оны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжид тусгагдсан ажлуудыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас, бүтэн жилийн тайлангийн хамт үр дүнг үнэлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс ирүүлнэ.</p>	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, шалган зааварласан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх 16 ажлыг төлөвлөн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар баталж, тайлант хугацаанд хэрэгжилтийг 90 хувь ханган ажиллаж байна.</p>
<p>1.13. Албан үүргээ гүйцэтгэхдээ нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдтэй холбоотойгоор олон нийтэд төрийн албан хаагч, төрийн албанд эргэлзээ төрүүлэх, итгэлийг алдах шинжтэй аливаа үйлдэл, эс</p>	<p>Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч буй мэдүүлэг гаргагч 8 албан тушаалтны 2017 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргаж ба ХАСХОМ-1 тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 03/90 дугаар албан бичгээр НЗДТГ-ын</p>

<p>үйлдэхүй гаргахгүй байна.</p>	<p>ТЗУХ-т хүргүүлсэн.</p> <p>Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 153 төлөөллийн “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг хянаж “shilendans.gov.mn” системд мөн тус газраас үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан 46 төлөөллийн мэдэгдлийг АТГ-ын цахим системд байршуулж, мэдүүлсэн.</p>
<p>1.14. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллана.</p>	<p>“Төсвийн сахилга бат хариуцлагыг сайжруулах” төлөвлөгөөг 2018 оны А/08 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн 2018 онд нийслэлийн төсвөөс тус байгууллагад 496,421.6 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, 20,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн. Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, ер авлага үүсгээгүй ажилласан ба 63,072.6 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан байна.</p>
<p>1.15. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлын хариуцан ажиллана.</p>	<p>Шилэн дансны тухай хуульд заасны дагуу</p> <ul style="list-style-type: none"> • Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5,000.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээлэл • Худалдан авах ажиллагааны ил тод байдлын хүрээнд тус газраас үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдсон 153 төлөөллийн “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”, Нийслэлийн Засаг даргаас тус газарт эрх шилжүүлэн зохион байгуулагдаж гэрээ байгуулагдсан 63 ажлын мэдээлэл • Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд байгууллагын бүтэц орон тооны

	<p>өөрчлөлт хөдөлгөөний талаарх 1-6 сарын мэдээлэл зэргийг цаг хугацааны хоцрогдолгүй тухай бүр агуулга, нийтлэг стандартын дагуу байршуулсан.</p>
<p>1.16. Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.</p>	<p>Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж эд, хөрөнгө болон хангамжийн материалын тооллогыг төлөвлөгөөний дагуу явуулах зорилгоор байгууллагын хөрөнгийг өмчийн програм болон НӨХГ-ын хөрөнгийн програмд бүртгэн, коджуулсан. “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2018 оны А/50 дугаар тушаалаар шинэчлэн томилж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу НӨХГ-т хүсэлт гаргаж эвдрэлтэй, элэгдлийн хугацаа дууссан хөрөнгийг актлуулж шийдвэрлүүлсэн.</p> <p>Байгууллагын үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг үндэслэн Эд хөрөнгийн тооллогын комисс болон Өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж, санхүүгийн тайланд бүртгэлтэй машин, тоног төхөөрөмжүүдээс элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>Тус газраас 2017 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай хийсэн нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дүгнэж, нийт 85 оноо авахаас 84 оноо буюу “Бүрэн хангалттай” үнэлгээ авч ажилласан.</p>
<p>1.17. Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй www.edoc.ub.gov.mn болон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх, шүүхэд хянан хэлэлцэгдэж буй хэргүүдийн явцын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглагдаж байгаа www.smartcity.mn цахим хуудсыг хөтлөх.</p>	<p>Байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем www.edoc.ub.gov.mn болон өргөдөл гомдлын нэгдсэн систем www.smartcity.mn-ийг тогтмол хэрэглэж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд хариутай 170, хариугүй 510, нийт 680 албан бичиг системд бүртгэгдэн байгууллагын хяналтад байна. Үүнээс шийдвэрлэгдсэн бичгийн тоо 652, шийдвэрлэх шатандаа байгаа бичгийн тоо 9, хугацаа хэтрэн шийдвэрлэсэн бичгийн тоо 19 байна. Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.7%, үүнээс ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.5% байна.</p> <p>Тайлант хугацаанд 33 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цахим системд бүртгэн дунджаар ажлын 5 хоног 17 цаг 43 минутад хуулийн дагуу шийдвэрлэсэн.</p>

<p>1.18. Эрхлэх асуудлын хүрээнд шүүхэд үүссэн маргаанд Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох бөгөөд үүсэх аливаа үр дагаврыг Засаг даргын өмнө бүрэн хариуцана.</p>	<p>Тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд шүүхэд маргаан үүсээгүй.</p>
<p>1.19. Үр дүнгийн гэрээний биелэлтийг “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу хагас, бүтэн жилээр Нийслэлийн Засаг даргын асуудал хариуцсан орлогчид тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс ирүүлэх бөгөөд үр дүнгийн гэрээний биелэлт, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.</p>	<p>Төсвийн шууд захирагчийн 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу хагас 2018 оны 06 сарын 29-ний өдрийн 01/838 дугаар албан бичгээр хүргүүлж байна.</p>

Тайлан бичсэн:

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГҮНДСАМБУУ

2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Үнэлгээ өгсөн:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД